M CARGO – ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

Хүчинтэй огноо: 2025-10-27-оос 2025-12-31
Үйлчилгээ үзүүлэгч: M CARGO
Үйлчлүүлэгч: (цаашид “Харилцагч” гэх)

---

1. Ерөнхий заалт

1.1. Энэхүү нөхцөл нь M Cargo-ийн бүх үйлчилгээнд хамаарна.
1.2. Харилцагч үйлчилгээ авахын өмнө үйлчилгээний нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болно.
1.3. M Cargo нь хууль, дүрэм журам, гаалийн болон олон улсын тээврийн стандартын өөрчлөлт орсон тохиолдолд нөхцөлийг шинэчлэх эрхтэй бөгөөд урьдчилан мэдэгдэнэ.

---

2. Үйлчилгээний хүрээ

2.1. M Cargo нь Хятад улсын Эрээн салбарын агуулахын хаягаа ашиглуулан илгээмж хүлээн авч, Монгол Улс, Улаанбаатар хот хүртэл тээвэрлэх үйлчилгээ үзүүлнэ.
2.2. mcargo.mn платформ нь хаяг холбох, илгээмж бүртгэх, хянах, төлбөр төлөх, хүргэлт захиалах зэрэг үйлчилгээ үзүүлнэ.

---

3. Тээврийн үнэ ба төлбөр

3.1. Тээврийн үнэ нь илгээмжийн жин эсвэл оврын аль ихээр тооцогдоно.
1кг 3000₮, ачааны төрөл, онцлогоос хамааран 1м.куб 300000₮~400000₮.
3.2. Харилцагчийн хүсэлтээр хийгдсэн нэмэлт сав баглаа боодол, гаалийн бүрдүүлэлт, бичиг баримт бүрдүүлэлт, хүргэлт гэх мэт нь тээврийн үнэ дээр нэмэгдэж бодогдоно.
3.3. Тээврийн үнэ нь шатахуун, гаалийн татвар, гадаад ханшийн хэлбэлзэл, ачааны онцлог, агуулахын шаардлагаас хамааран өөрчлөгдөж болно.

---

4. Тээвэрлэлтийн хугацаа ба нөхцөл

4.1. Хятад агуулахаас Монгол руу тээвэрлэх хугацаа ойролцоогоор 3–10 хоног байна.

4.2. Байгалийн гамшиг, хил хаах, давагдашгүй хүчин зүйл, улс, төрийн зохицуулалт, гуравдагч этгээдийн үйлдлээс үүдэлтэй саатлыг M Cargo хариуцахгүй.
4.3. Барааны шинж чанар, сав баглаа боодол хангалтгүйгээс үүдсэн хохирлыг харилцагч хариуцна.

---

5. Эрсдэл ба хариуцлага

5.1. Харилцагч, ачааны бүрэн бүтэн байдлыг M Cargo-с хүлээн авахын өмнө шалгаж, баталгаажуулна.
5.2. Давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй хохирлыг M Cargo хариуцахгүй.
5.3. Буруу мэдээлэл, буруу хаяг холболт, бичиг баримт дутуугаас үүдсэн алдаа болон буруу хүргэлтийн хариуцлагыг харилцагч хариуцна.
5.4. Шууд бус хохирол (орлого алдах, барааны үнэ буурах, хугацааны алдагдал) M Cargo-ийн хариуцлагад хамаарахгүй.

---

6. Даатгал ба нөхөн төлбөр

6.1. Бүх олон улсын илгээмжийг M Cargo албан ёсны даатгалд хамруулна.
6.2. Даатгалын нөхөн төлбөрийг хохирол баталгаажсанаас хойш 21 хоногийн дотор шийдвэрлэнэ.
6.3. Харилцагч бараагаа салбараас болон хүргэлтээр хүлээн авахдаа шалгаж авах үүрэгтэй ба зөвхөн уг тохиолдолд гомдол гаргах эрх үүснэ.

---

7. Агуулах ба хадгалалт

7.1. Илгээмж Улаанбаатар салбарт ирснээс хойш 7 хоногийн дотор хүлээн авах үүрэгтэй.
7.2. Хугацаа хэтэрвэл хадгалалтын төлбөр нь хоног тутамд тээврийн үнийн 1%-аар тооцогдоно.
7.3. Хадгалалтын төлбөр нийт тээврийн үнийн 80%-д хүрвэл илгээмжийг буцаах буюу агуулахаас чөлөөлөх эрхтэй.

---

8. Хориглосон бараа

8.1. Дараах барааг тээвэрлэхийг хориглоно:

- **Тэсрэх, шатамхай, хорт бодис**
- **Хүнс, эм, шингэн, шилэн эдлэл**
- **Зэвсэг, хуульд хориглосон бараа**
- **Амьд амьтан, ургамал, тэдгээрийн үндэс, үр**
  8.2. Хориглосон бараанаас үүсэх хохирол, гаалийн хураамжийг Харилцагч бүрэн хариуцна.

---

9. Нууцлал

9.1. Харилцагчийн хувийн мэдээллийг M Cargo зөвхөн үйлчилгээний хүрээнд ашиглана.
9.2. Хуульд заасан тохиолдлоос бусад үед гуравдагч этгээдэд дамжуулахгүй.
9.3. Харилцагч өөрийн дансны нууцлал, сайтад нэвтрэх мэдээлэл, илгээмжийн мэдээллээ хамгаалах үүрэгтэй.

---

10. Гомдол шийдвэрлэлт

10.1. Гомдлыг info@mcargo.mn хаягаар эсвэл M Cargo цахим сувгуудаар хүлээн авч шийдвэрлэнэ.
10.2. Шаардлагатай тохиолдолд даатгалын байгууллага болон мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран шалгалт хийж болно.

---

11. Ажлын цагийн хуваарь

- **Даваа–Баасан: 10:00–19:00**
- **Бямба: 11:00–16:00**
  📞 **Утас: 77088899**
  🌐 **Веб: www.mcargo.mn**